



ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 07 сарын 26 өдөр

Дугаар Б/45

Чингис хот

М.Урандолгиог түр орлон гүйцэтгэгчээр
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, 33.4, Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2, Засгийн газрын 2011 оны 62 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журам"-ын 3.3, 3.3.4, 4.3, 4.3.3, 4.4, 2014 оны "Зарим албан тушаалын цалингийн жишгийг шинэчлэн тогтоох тухай" 332 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Мягмарбаатарын Урандолгиог Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дотоод, гадаад харилцаа, шагнал, ёслолын асуудал хариуцсан мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр 2017 оны 07 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн томилсугай.

2. М.Урандолгиогийн цалинг ТЗ-5-1 шатлалаар тогтоон үндсэн цалин 509948 /таван зуун есөн мянга есөн зуун дөчин найман/ төгрөгөөр тооцож олгохыг нягтлан бодогч /Н.Шинэбаяр/-д зөвшөөрсүгэй.

3. Ажил хүлээлцүүлэх ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн
ахлагч:

Ж.Гантулга

-Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Гишүүд:

С.Оюун-Эрдэнэ

-Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн

Т.Баяртуяа

-Аж ахуйн нярав

4. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дотоод, гадаад харилцаа, шагнал, ёслолын асуудал хариуцсан мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг М.Урандолгиогд үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР